



МОНГОЛ УЛСЫН
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А-267

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй Газрын тос боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах тос дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/-ийн ажлын даалгавар боловсруулах, трассыг эцэслэн тогтоох, уг трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал, дүгнэлт боловсруулж танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, Ажлын хэсгийн баримтлах удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Ажлын хэсгийн ажлыг шуурхай зохион байгуулж, явцыг тухай бүр, эцсийн дүгнэлтийг 2020 оны 12 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Б.Анхбаяр/-д, Ажлын хэсэгт шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газрын орлогч дарга /Ц.Эрдэнэбаяр/, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал /Д.Алтанцэцэг/ нарт тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Нандинжаргал/-д даалгасугай.




Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2020 оны 10-р сарын 23-ны өдрийн
А-267 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Анхбаяр	УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газрын дарга
Ажлын хэсгийн дэд ахлагч:	Ц.Эрдэнэбаяр	Ашигт малтмал, газрын тосны газрын орлогч дарга
	Д.Алтанцэцэг	Монгол газрын тос боловсруулах үйлдвэр ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал
Гишүүд:	Ч.Чулуунбат	УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга
	Ж.Банзрагч	БХЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн, Дэд хурандаа
	Ч.Хишигдалай	УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын газрын ахлах шинжээч
	Г.Болормаа	БХБЯ-ны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч
	Ж.Энхчимэг	БХБЯ-ны Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын мэргэжилтэн
	Ж.Болдхүү	ЗТХЯ-ны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч
	М.Угтахбаяр	ЗТХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын шинжээч
	Н.Мөнхбат	ЭХЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн
	М.Тулга	БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын мэргэжилтэн
	Н.Отгонсүрэн	АМГТГ-ын Кадастрын хэлтсийн мэргэжилтэн
	П.Оюунтуяа	АМГТГ-ын Хүнд үйлдвэр, техник технологийн хэлтсийн мэргэжилтэн
	Б.Энхбат	МГТБҮ ТӨХХК-ийн албаны дарга
	Л.Орхон	МГТБҮ ТӨХХК-ийн Процессын инженер
	Н.Нямпүрэв	МГТБҮ ТӨХХК-ийн Дулааны инженер
	Д.Бадарч	МГТБҮ ТӨХХК-ийн Хяналтын инженер
	Н.Гэрэлцэцэг	Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Х.Отгонжаргал	Дорноговь аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	М.Гэрэлт-Од	Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:	Б.Баяржаргал	УУХҮЯ-ны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн шинжээч
	О.Түмэн-Өлзий	МГТБҮ ТӨХХК-ийн Ахлах мэргэжилтэн

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын
2020 оны 10-р сарын 27-ны өдрийн
А.Х.Т дугаар тушаалын 2 дугаар хэвсрэлт



АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

Гүйцэтгэх ажлууд:

1. Дорнод аймгийн Матад сумын нутаг, газрын тосны ашиглалтын Тосон Уул-ХИХ талбайгаас Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж буй газрын тос боловсруулах үйлдвэр хүртэлх дамжуулах хоолойн трассыг эцэслэн тогтоох, уг трассын дагуух газрыг улсын тусгай хэрэгцээнд авах талаар санал, дүгнэлт боловсруулах, шаардлагатай бол холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах, газрыг улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдсон шийдвэрийн төсөл боловсруулах
2. Трассын дагуу төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугамтай давхцал, огтлолцол байгаа эсэх, улсын болон аймаг, сумын тусгай хэрэгцээний газар, аж ахуйн нэгж, хувь хүний эзэмшил, малын бэлчээр зэргийг нягтлан тодорхойлох;
3. Тос дамжуулах хоолойн техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгавар боловсруулах, холбогдох тооцоолол, судалгаа, мэдээллээр захиалагч байгууллагыг хангах.

---oOo---